



ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Ордын нөөц	4
1.3. 2024 оны ил уурхайн төлөвлөлт	5
1.3.1. Уулын ажлын одоогийн байдал	5
1.3.2. Ашиглалтын технологи, горим	5
1.3.3. Ил уурхайн гүн, хүрээ хязгаар	6
1.3.4. Ил уурхайн хүчин чадал, уулын ажлын горим	6
1.3.5. Ил уурхайн элс олборлолтын хүчин чадал	7
1.3.6. Уурхайн ажлын горим	7
1.3.7. Уулын ажлын өрнөл дараалал	8
1.3.8. Хөрс хуулалтын технологи	8
1.3.9. Олборлолтын технологи	9
1.3.10. Уулын ажлын процессууд	9
1.3.11. Овоолгын процесс	10
1.4. Баяжуулалтын технологи	10
1.5. Дэд бүтэц	10
2. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	13
3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
3.1. Тухайн жилийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
3.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	18
3.4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	18
3.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
3.8. БОМТ -г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	22
3.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22
3.10. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр	23



ХҮСНЭГТҮҮД

<i>Хүснэгт №1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбилицол</i>	3
<i>Хүснэгт №2. Тогоотын ам, Шийрийн хөндийн алтны шороон ордын нөөцийн нэгдсэн тооцоо</i>	4
<i>Хүснэгт №3. Уулын ажлын механикжуулалтын бүтэц</i>	6
<i>Хүснэгт №4. Ил уурхайн 2024 оны нийт уулын ажлын хэмжээ</i>	6
<i>Хүснэгт №5. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа</i>	7
<i>Хүснэгт №6. 2024 оны уулын ажлын төлөвлөгөө</i>	8
<i>Хүснэгт №7. “Шийрийн хөндий” ордын элс олборлолт /2024 он/</i>	10
<i>Хүснэгт №8. Элс угаалт бүтээгдэхүүн гаргалт /2024 он/</i>	10
<i>Хүснэгт №9. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн сонголт</i>	10
<i>Хүснэгт №10. Гүний худгийн мэдээлэл</i>	11
<i>Хүснэгт №11. Жилд шаардлагатай технологийн усны нийт хэрэглээ</i>	11
<i>Хүснэгт №12. Хоногт шаардаагатай технологийн усны хэрэглээ</i>	11
<i>Хүснэгт №13. Технологийн усан сангийн багтаамж</i>	12
<i>Хүснэгт №14. Төсөл хэрэгжих талбайн ашиглалтын төлөв байдал /2024 оны байдлаар/</i>	13
<i>Хүснэгт №15. Уурхайн үйл ажиллагаагаар эвдэгдсэн газрын хэмжээ</i>	14
<i>Хүснэгт №16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i>	16
<i>Хүснэгт №17. 2024 оны нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал</i>	18
<i>Хүснэгт №18. Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</i>	19
<i>Хүснэгт №19. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт</i>	20
<i>Хүснэгт №20. Хог, хаягдаан менежментийн төлөвлөгөө</i>	21
<i>Хүснэгт №21. БОМТ -г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлagnaх хувваар</i>	22
<i>Хүснэгт №22. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө</i>	22
<i>Хүснэгт № 23. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр</i>	23

ХАВСРАЛТ ЗУРАГНУУД

<i>Зураг №1. Төсөл хэрэгжиж буй талбайн зураг</i>	3
<i>Зураг №2. Төслийн талбайн байршилын зураг /Google earth/</i>	4
<i>Зураг № 3. Орчны хяналт шинжилгээний цэгийн байршилын зураг</i>	25

ХАВСРАЛТУУД

1. ААН-ийн гэрчилгээний хуулбар
2. MV-017405 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар
3. ЭБМЗ-ийн дүгнэлт, тушаалын хуулбар
4. ТЭЗҮ-ийн дүгнэлт, тушаалын хуулбар
5. Байгаль орчны лавлагаа
6. Барьцаа төлбөрийн баримтын хуулбар
7. Байгаль орчны менементийн төлөвлөгөөний биелэлтийн дүгнэлт /2023 он/
8. Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан тухай акт /202 он/
9. Хяналтын хуудас
10. Нөөцийн хөдөлгөөний Маягт №3а
11. Уулын ажлын төлөвлөгөөний нүүр, маягтууд
12. БОНБНҮнэлгээний тайлангийн нүүр
13. Аудитын тайлангийн дүгнэлт /”Ногоон гэрэлт ирээдүй” ХХК, 2022 он/
14. Аймгийн санал



1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

“Тогоотын ам”, “Шийрийн хөндийн” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч:

Хувийн хөрөнгө оруулалттай “Ай Эн Ди” ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011680028, Регистрийн дугаар: 5083265, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017405, Гүйцэтгэх захирал: Д.Содбилиг

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 2 -р хороо, Болор бизнес төв 303 тоот, Утас: 99092869

Төслийн байршил:

“Тогоотын ам” болон “Шийрийн хөндий” нэrtэй орд нь Баянхонгорын алтны бүсийн Бөмбөгөрийн хүдрийн дүүргийн Бумбат булагийн хүдрийн зангилаанд орших ба ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт харьяалагдана. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун зүгт 760 км-т, Баянхонгор аймгийн төвөөс 98 км, Бөмбөгөр сумын төвөөс зүүн урагш 22 км зайд 1724.73 га талбайг хамран байрлаж байна.


Хүснэгт №1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицол

Д/д	Үртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	99	53	10.00	46	12	41.57
2	99	52	20.46	46	12	41.87
3	99	52	20.46	46	9	41.58
4	99	56	05.00	46	9	41.58
5	99	56	05.00	46	10	45.00
6	99	54	58.00	46	10	45.00
7	99	54	58.00	46	11	41.00
8	99	53	10.00	46	11	41.00



Эх үүсвэр : Байгаль орчны төлөв байдлын хээрийн судалгаа, 2022 он

Зураг №1. Төсөл хэрэгжиж буй талбайн зураг



Эх үүсвэр : Google earth. 2024 он

Зураг №2. Төслийн талбайн байршилын зураг /Google earth/

1.2. Ордын нөөц

Анх ашигт малтмалын ашиглалтын MV-017405 тоот тусгай зөвшөөрлийг АМГ-ын КХ-аас “Ай Эн Ди” ХХК -д 2013 оны 10 дүгээр сарын 17-ний өдөр олгосон болно.

“Ай Эн Ди” ХХК нь 2012-2013 онд өөрийн хөрөнгөөр “Салхит” -ын 554.7 гектар талбайд өрөмдлөгийн ажлаар хайгуул хийж, шурф нэвтрэлтээр өрөмдлөгийн ажлын үр дүнг баталгаажуулан, алтны шороон ордын нөөцийг тогтоосон байна.

Хүснэгт №2. Тогоотын ам, Шийрийн хөндийн алтны шороон ордын нөөцийн нэгдсэн тооцоо

Блокийн дугаар	Зузаан, м		Дундаж агуулга, мг/м ³	Блокын талбай, мяня.м ²	Эзэлхүүн, м ³		Металлын нөөц, кг			
	Хучаас	Давхарга			Хучаас	Давхарга	Шлих	Цэвэр		
<u>Сорьц-856</u>										
"Тогоотын ам"										
1-C	2.7	2.2	191	8.97	24.52	19.73	3.78	3.23		
2-C	4.0	2.7	227	5.89	23.56	15.90	3.60	3.09		
3-C	2.9	0.9	297	4.80	13.92	4.32	1.28	1.10		
4-C	3.2	0.9	275	7.38	23.62	6.89	1.89	1.62		
5-B	2.8	2.1	209	15.40	43.12	31.57	6.59	5.64		
6-B	3.5	1.0	293	24.40	85.40	25.10	7.36	6.30		
7-B	1.8	1.9	254	17.80	32.40	34.53	8.76	7.50		
8-B	3.6	1.6	267	24.60	88.21	40.41	10.79	9.24		
9-B	2.3	2.3	249	35.50	82.83	79.99	19.94	17.07		
10-B	1.8	1.7	241	12.80	23.04	22.19	5.34	4.57		
11-B	1.1	1.6	238	13.30	14.44	21.28	5.06	4.33		
12-B	1.0	1.3	219	22.30	23.19	28.99	6.35	5.43		
13-B	1.3	1.2	264	35.70	44.94	42.42	11.21	9.59		
14-B	1.2	1.2	338	34.90	41.49	42.27	14.30	12.24		
15-B	0.9	1.3	399	19.14	16.46	24.88	9.93	8.50		
16-B	1.9	1.2	354	5.60	10.83	6.72	2.38	2.04		



17-С	0.8	1.5	367	6.60	5.54	10.03	3.68	3.15
18-С	3.0	0.8	206	1.00	3.00	0.80	0.16	0.14
Бүгд				296.08	600.51	458.03	122.40	104.77
В- зэрэглэл				261.44	506.35	400.35	107.99	92.44
С- зэрэглэл				34.64	94.16	57.68	14.41	12.33
Ордын дундаж	2.0	1.5	267					
“Шийрийн хөндий”								
1-С	2.8	1.4	319	1.43	4.00	2.00	0.64	0.55
2-С	1.6	1.1	304	2.83	4.53	3.11	0.95	0.81
3-В	3.8	1.3	337	7.76	29.49	9.70	3.27	2.80
4-В	1.9	1.0	289	20.63	39.43	21.55	6.23	5.33
5-В	2.5	1.2	287	20.94	52.12	25.13	7.21	6.17
6-В	1.8	1.3	297	15.04	27.07	18.80	5.59	4.78
7-В	2.0	1.2	284	13.03	25.73	14.98	4.26	3.64
8-В	2.2	1.0	265	16.13	34.77	16.85	4.46	3.82
9-В	2.3	1.2	262	9.73	21.96	11.68	3.06	2.62
10-В	2.2	1.4	287	9.74	21.82	13.64	3.92	3.35
11-В	2.3	1.1	309	19.54	44.55	22.28	6.88	5.89
12-В	1.7	1.0	285	12.58	21.93	12.22	3.48	2.98
13-С	1.5	0.9	299	4.54	6.96	4.24	1.27	1.09
14-В	2.4	1.1	292	8.00	18.80	8.40	2.45	2.10
15-В	1.8	1.5	244	9.37	17.24	13.87	3.38	2.89
16-В	1.8	1.3	239	12.39	21.95	16.28	3.89	3.33
17-В	2.1	1.1	248	8.17	17.16	8.99	2.23	1.91
18-В	2.1	1.3	264	6.86	14.41	8.58	2.26	1.93
19-В	2.4	1.3	301	10.01	24.42	13.21	3.98	3.41
Бүгд				208.72	448.33	245.49	69.39	59.40
В - зэрэглэл				228.92	432.84	236.14	66.53	56.95
С- зэрэглэл				8.80	15.49	9.35	2.86	2.45
Ордын дундаж	2.1	1.2	283					
Нийт				504.80	1048.84	703.52	191.79	164.17
в- зэрэглэл				461.36	939.19	636.49	174.53	149.39
С- зэрэглэл				43.44	109.65	67.03	17.26	14.78

1.3. 2024 оны ил уурхайн төлөвлөлт

1.3.1. Уулын ажлын одоогийн байдал

2019, 2021, 2022, 2023 онуудад 4-В ,5-В, 6-В, 7-В, 8-В, 9-В, 10-В, 11-В, 12-В, 13-С, 14-В, 15-В, 16-В, 17-В, 18-В, 19-В блокуудыг бүрэн олборлож угаан баяжуулсан.

2024 онд бэлтгэл ажил бүрэн хангагдсан учир өөрийн бүрэн хүчин чадлаар үйлдвэрлэлийн ажлыг явуулж “Шийрийн хөндий” хэсгийн 1-С, 2-С, 3-В, Тогоот хэсгийн 9-В блокуудыг бүрэн олборлоо төлөвлөөд байна.

1.3.2. Ашиглалтын технологи, горим

“Шийрийн хөндий” алтны шороон орд нь зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон 2 км орчим урттай бөгөөд хамгийн өргөн нь 9-В, 10-В, блокуудын заагт 100 м, хамгийн нарийн хэсэг нь 17-В, 18-В, блокуудын заагт 40 м байна. Ордын сунал болон хөндлөн чиглэлд алттай давхарга, алтны агуулгын өөрчлөлт, ордод хийгдсэн геологийн судалгааны ажлын түвшин зэргээрээ уг орд нь алтны шороон ордын нөөцийн ангилалаар III бүлэгт хамарагдах юм.

“Шийрийн хөндий” алтны шороон орд нь зүүн хойноос баруун урагш 2 км орчим сунаж тогтсон бөгөөд хучаас хөрсний хэмжээ харьцангуй бага буюу 1.5-3.8 м зузаантай юм.



Дээрх нөхцөлүүд нь ордыг ил аргаар олборлох уул-техникийн таатай нөхцлийг бүрдүүлж байна. Иймд уг ордын геологийн тогтоц болон хөрсний зузаан зэргээс хамааруулан авто тээвэртэй гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд дараах механикжуулалтын бүтцийг хөрс хуулалт, олборлолтын ажилд тохиромжтой гэж үзэж байна.

Хүснэгт №3. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Ажил	Пронессууд (тоног төхөөрөмж)		
Шимт хөрс хуулалт	Ухаж түрэх	Шимт хөрс хуулалт	Ухаж түрэх
	Бульдозер	Утгуурт ачигч	Автосамосвал
Хөрс хуулалт	Ухаж түрэх		Овоолох
	Бульдозер		Бульдозер
Элс олборлолт, боловсруулалт	Ачих	Тээвэрлэлт	Алт ялган авах
	Эксаватор	Автосамосвал	Угаах төхөөрөмж

1.3.3. Ил уурхайн гүн, хүрээ хязгаар

Ил уурхайн гүн

"Шийрийн хөндий" алтны шороон ордын ил уурхайн гүн нь хөрс болон элсний зузаан, улны бохирдлын зузааны нийлбэрээр илэрхийлэгдэх бөгөөд тус ордын хувьд уурхайн хамгийн бага гүн нь нөөцийн 13-С хэсэгшилд 1.5 м, харин хамгийн их гүн нь нөөцийн 3-В хэсэгшилд 3.8 м байхаар тооцоо гарсан.

Ил уурхайн хүрээ, хязгаар

Орд нь хэдийгээр III бүлгийн ордод хамаарч буй боловч ЭБМЗ-ийн хуралдаанаас 2013 оны 07-р сарын 08 өдөр гаргасан XX-15-02 тоот нөөцийн дүгнэлтийн 11-д ордын бодитой болон боломжтой нөөцөд тулгуурлан уг ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах боломжтой гэж заасны дагуу 1-С, 2-С болон 13-С нөөцийн хэсэгшлүүдийг уурхайн үйлдвэрлэлийн нөөцөд хамааруулан тооцоолсон.

Уурхайн хүрээ хязгаар нь ордын нөөц бодсон талбайн хэмжээнд тодорхойлогдох бөгөөд уг ордын хувьд хайгуулын ажлын үр дүнгээр тооцогдож Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгэгдсэн нөөцийг бүрэн хэмжээнд олборлох бүрэн боломжтой юм.

Уурхайн хөрс хуулалтын ажлыг бульдозeroор гүйцэтгэх бөгөөд харин элс олборлолтыг экскаватор автосамосвалын хослогоор гүйцэтгэнэ. Иймд уурхайн доголын нүүрний өнцөг нь болон доголын өндөр дараах хэмжээстэй байна гэж үзсэн. Үүнд:

- Хөрс хуулалтын доголын өндөр (Хучаас хөрс - 0.1) м;
- Хөрсний доголын нүүрний өнцөг бульдозерийн түрэх хэм 9 град (Элсний зузаан + 0.2) м 70 град
- Элсний доголын өндөр
- Элсний доголын нүүрний өнцөг

1.3.4. Ил уурхайн хүчин чадал, уулын ажлын горим

Хүснэгт №4. Ил уурхайн 2024 оны нийт уулын ажлын хэмжээ

№	Үзүүлэлт	Нэгж	Хэмжээ
1	Уулын цул	мян.м ³	227.45
2	Элсний хэмжээ	мян.м ³	95.53
3	Хөрс хуулалтын хэмжээ	мян.м ³	125.73
4	Шимт хөрс	мян.м ³	19.82



1.3.5. Ил уурхайн элс олборлолтын хүчин чадал

Орд нь тогтцын хувьд зүүн хойноос баруун урагшаа сунаж тогтсон, 0-3 градусын хэвтээ уналтай бөгөөд алт агуулсан давхаргын хувьд ямар нэгэн цэвдэгшил болон усны хүндрэл байхгүй юм.

2024 онд төлөвлөж буй ил уурхайн хүрээн дэх нийт хуулах хөрсний хэмжээ нь 125.20 мян.м³, олборлох элсний хэмжээ нь 95.53 мян.м³ байхаар тооцоо гарсан. Орд байрлаж буй Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын хэсэг нь үйлдвэрлэлд ашиглах гадаргын устай бөгөөд газрын гүний усыг их хэмжээгээр авч ашиглахад хязгаарлагдмал юм. Учир нь уг талбайд гаргасан 2 ширхэг худгийн нийт ундарга нь 11.6 л/с байгаа бөгөөд бид энэхүү усны эх үүсвэр болон тухайн ордын дэргэдэх карьерын шүүрлийн усыг насосоор соруулан цэвэр усны нуурт сэлбэх боломжтой юм. Иймд нийт усны эх үүсвэр, уурхайн жилд ажиллах хоног, хоногт ажиллах цаг, эргэлтийн усны хэмжээ гэх мэт үзүүлэлтээс шалтгаалан уурхайн элс олборлолтын хүчин чадлыг жилд 125 мян.м³ элс угаан баяжуулахаар төлөвлөсөн. Харин уурхайн хөрс хуулалтын хэмжээ нь тухайн жилд олборлолтонд өртөх нөөцийн хэсэгшил дэх хөрсний зузаанаас хамааран өөр өөр байна.

1.3.6. Уурхайн ажлын горим

Уурхайн бэлтгэл үйл ажиллагаа 04-р сарын 15-аас уурхайн талбайд эхэлэх бөгөөд эхний ээлжинд уурхайн талбайд угаах төхөөрөмж байрлуулах, уурхайн тосгон байгуулах, худгуудын холболт хийх, усан сангудыг байгуулах, техникийн бэлэн байдлыг хангах зэрэг ажил хийгдэх бөгөөд үүнд нийт 15 хоногийг зарцуулна. Уурхайн хөрс хуулалтын ажил 05-р сарын 01-ээс эхлэн хийгдэж эхэлэх бөгөөд элсийг ухаж ачих ажил хийх боломжтой хэмжээний талбай бэлэн болох хугацаа буюу эксковаторын ажлын бүтгээмжээр 2 хоногийг дараагаас элс олборлолтын ажил эхэлсэн бөгөөд элс угаах ажил элс олборлох ажлыг дагалдан 2 хоногийн дараагаас эхэлсэн болно. Тухайн бүс нутаг нь.gov хээрийн бүсэд хамаарах тул намартаа дулаан тогтуун байдаг бөгөөд орд орчимд ажиллаж буй алтны уурхайнууд нь 11 сарын эхэн хүртэл ажилладаг бөгөөд бид уурхайн ажлыг 10-р сарын 20-нд баяжуулалтын ажил зогссож нөхөн сэргээлтийн ажил 11 –р сарын 05 хүртэл үргэлжлүүлэн хийгдэх болно.

Уурхай нь хоногт хоёр ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг ажилласан ба шлюз авах, ээлж солилцох, хоолонд орох хугацааны нийлбэр нь 2 цаг байна. Монгол Улсын “Хөдөлмөрийн хууль”-нд заасны дагуу жилд амрах баяр, ёслолын хоног, цаг агаарын хүндрэлтээс шалтгаалан ил уурхайн ажиллагаа сул зогсож болзошгүй хугацааг тооцоход уурхай нь жилдээ 152 хоног ажиллах бөгөөд үүнд уурхайн хавар бүр ажил эхлэхийн өмнө хийгдэх бэлтгэл ажлын хугацаа багтсан болно.

Хүснэгт №5. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа

№	Үзүүлэлт	Х.н	Хэмжээ
1	Жилийн ажиллах хуанлийн өдөр	хоног	158
2	Баяр ёслолын үеийн амралтын өдөр	хоног	5
3	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар	хоног	7
4	Цаг агаарын саатал	хоног	5
5	Уурхайн ажиллах хоног	хоног	141
6	Ажил эхлэхийн өмнөх бэлтгэл ажил	хоног	14
7	Хөрс хуулалтын ажлын хоног	хоног	125
8	Элс олборлолтын ажлын хоног	хоног	125



9	Элс угаах ажлын хоног	хоног	128
10	Хоногт ажиллах ээлжийн тоо		2
11	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
12	Ээлж солилцох, шлоз авах, хооллох хугацаа	цаг	2

1.3.7. Уулын ажлын өрнөл дараалал

2024 онд: Уурхайн нээлтийг “Шийрийн хөндий” ордын хамгийн хойд хэсгийн 1-С, 2-С, 3-В блокоос эхлэн экскаваторын үргэлжилсэн гарцаар нээхээр төлөвлөсөн. Учир нь ордын урд хэсэгтээ элсэн дэх алтны дундаж агуулга өмнөд хэсгээ бодвол өндөр юм. Ухаж ачихад бэлтгэгдсэн нөөцийн гадаргын талбайн хэмжээ нь хэсэгшлийн уртын дагуу 50 м харин өргөн нь хэсэгшлийн өргөнтэй тэнцүү байсан. 2024 онд уулын ажил “Шийрийн хөндий” хэсгийн 1-С, 2-С, 3-В хэсэгшил, “Тогоот” хэсгийн 9-В хэсэгшлийг бүхэлд нь олборлох тооцоо гарсан. 2024 онд нийт 125.20 мян.м³ хөрс хуулж, 206 мг/м³ дундаж агуулгатай 95.53 мян.м³ элс олборлохоор төлөвлөөд байна.

Хүснэгт №6. 2024 оны уулын ажлын төлөвлөгөө

№	Блокийн дугаар	Уулын цул, м ³		Дундаж агуулга мг/м ³	Металл, кг	
		Хөрс	Элс		Шлих	Х.Цэвэр
1	1-С, 2-С, 3-В, 9-В	125.20	95.53	172	19.31	16.47
2	Нийт	125.20	95.53	172	19.31	16.47

1.3.8. Хөрс хуулалтын технологи

Хөрс хуулалтын ажил нь үржил шимт хөрсийг урьдчилан хуулах ба үндсэн хучаас хөрсийг хуулах гэсэн үндсэн 2 шатлалтай явагдана.

Нэгдүгээр үе шат. Уурхайн уулын ажлын ахилт, өрнөлтэй уялдуулан тухайн жилд ашиглалтанд өртөх талбайн болон нээлтийн хэсгийн хөрсний гадаад овоолгод дарагдах талбайн өнгөн хөрсийг уг бүс нутгийн хөрсний шимт болон шилжилтийн үеийн зузаанаас хамааруулан 0.1-0.3 хүртэлх зузаантайгаар хуулах бөгөөд уурхайн эцсийн хүрээний гадна талд салхины шууд нөлөөллөөс далд нөмөр газар овоолго үүсгэн хураана.

“Шийрийн хөндий” алтны уурхайн хувьд.gov хээрийн бүсэд хамаарах бөгөөд уг талбайд хийгдсэн газрын төлөв байдлын суурь судалгааны тайлангаас үзэхэд шимт болон шимэрхэг хөрсний үеийн зузаан дундажаар 0.2 м байна. Иймд шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар хуулна. Мөн үүнээс гадна үйлдвэрлэлийн зориулалтаар уурхайн болон зам талбай барилга байгууламж, угаах төхөөрөмж, элсний түр овоолго зэрэгт өртөн эвдэгдэх талбайнуудын үржил шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар урьдчилан хуулж хадгална. Тусгайлан хадгалсан үржил шимт хөрсийг уурхайн үйл ажиллагааны явцад болон үйл ажиллагаа дууссаны дараагаар уг эвдэгдсэн талбайд нөхөн сэргээлтийн ажил хийхэд ашиглана. Шимт хөрсний овоолгын өндөр нь 5м-ээс өндөр байж болохгүй.

Хоёрдугаар үе шат. “Шийрийн хөндий” алтны шороон ордын хувьд хучаас хөрсний хэмжээ харьцангуй нимгэн тул бульдозероор хуулахаар төлөвлөсөн бөгөөд уурхайд ашиглагдсан хоосон орон зайл бий болгож хөрсийг бульдозерын гадаад овоолгод хураасан бөгөөд ашиглагдсан орон зайл бий болсны дараагаар бульдозерын дотоод овоолгод байршуулна. Бульдозерын гадаад овоолго байгуулах үед хөрс хуулалтын доголын хажуугийн өнцөг 8-9 градус байна. Харин ашиглагдсан хоосон орон зайл руу ордын суналын дагуу түрэлт хийх бөгөөд нөөцийн хэсэгшлийг түүний өргөнөөс



хамааруулан 2-3 хувааж хөрс хуулалтын ажлыг явуулна. Бульдозерын түрэлтийн ажлын паспортыг доор үзүүлэв.

1.3.9. Олборлолтын технологи

3-В блокийн алт агуулсан элсний дундаж зузаан нь 1.3 м байгаа бөгөөд ул таазны бохирдлыг оруулаад 1.5 м орчим болсон. Ордын алт агуулсан давхаргыг экскаватор автосамосвалын хослолоор ухаж тээвэрлэнэ гэж тооцсон. Олборлолтын доголын өндөр нь элсний зузаан болон ул таазны бохирдолын зузаантай нийлбэртэй тэнцүү байна. Харин олборлолтын доголын налуугийн өнцөг нь элсний давхараасын зузаанаас 60-70 градус байна. Хөрс нь хуулагдсан талбайд 40-50 м урт фронтын дагуу ухаж ачих ажлыг гүйцэтгэх бөгөөд элс олборлолтонд ажиллах экскаваторын үзүүлэлтээс хамааран 8-10 м орлоор ажиллана.

Ашиглалтын системийн элементүүд

Олборлолтын доголын өндөр	Элсний зузаан+ хамгаалалтын цамц м
Хөрсний доголын өндөр	Хөрсний зузаан - таазны бохирдол м
Орлын өргөн	8-10 м
Автозамын өргөн	8.5 м
Олборлолтын фронтын урт	40-50 м

1.3.10. Уулын ажлын процессууд

Хөрсний хуулалтын процесс

Уурхайн хөрс хуулалтын ажлыг бульдозер болон экскаваторын хослолоор гүйцэтгэхээр төлөвлөсөн. Эхлээд уурхайн тухайн жилд олборлолтонд өртөх талбайн шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар бульдозероор хуулж утгуурт ачигч автосамосвалын хослолоор ачиж тээвэрлэн уурхайн хүрээний гадна 5 м -ээс өндөргүйгээр хураана. 2024 онд хуулсан нийт шимт хөрсний хэмжээ нь 19.82 мян.м³ байсан.

Уурхайн нийт хучаас хөрсний хэмжээ нь 125.20 мян.м³ байгаа бөгөөд хөрс хуулалтын ажил жилд 125 хоног үргэлжлэхээр төлөвлөсөн. Төсөл хэрэгжүүлэгчийн худалдан авахаар төлөвлөсөн XGMA TY160 маркийн 163.2 м.х хөдөлгүүрийн чадалтай бульдозерыг ашиглахаар сонгосон.

“Шийрийн хөндий” алтны шороон ордын хөрс хуулах ажилд XGMA TY160 маркийн бульдозер 1 ширхэг байхад хангалттай байна.

Элс олборлолтын процесс

Алт агуулсан элсийг экскаваторын тусламжтайгаар мөргөцгөөс шууд ухаж ачихаар тооцсон. Ордын нийт элсний хэмжээ 95.53 мян.м³ байх бөгөөд уурхайн технологийн усны эх үүсвэр болон хэрэглээнээс хамааран жилд 125.0 мян.м³ элс олборлохоор тооцсон. Элс олборлолтын ажилд төсөл хэрэгжүүлэгчид ашиглахад бэлэн байгаа Dooson DX300 маркийн 1.3 м³ утгуурын багтаамж бүхий экскаваторыг ажиллуулахаар сонгосон байна.

Эфел галь ачих процесс

Угаах төхөөрөмжөөс гарах эфель болон гаалийг 3 м³ утгуурын багтаамж бүхий XGMA XG95III маркийн утгуурт ачигчаар автосамосвалд ачихаар төлөвлөсөн.



Элс тээвэрлэх процесс

Алт агуулсан элсийг мөргөцгөөс угаах төхөөрөмж хүртэл авtosamosvalaар тээвэрлэх бөгөөд элс тээвэрт төсөл хэрэгжүүлэгчид бэлэн байгаа Howo маркийн 16 m^3 тэвшний багтаамж бүхий авtosamosvalыг ажиллуулахаар төлөвлөсөн байна.

1.3.11. Овоолгын процесс

1.4. Баяжуулалтын технологи

Баяжуулалтын технологи

Ил уурхайгаас олборлосон алт агуулсан элсийг авто тээврээр тээвэрлэн угаан баяжуулах төхөөрөмжийн дэргэдэх талбайд авч ирэх бөгөөд утгуурт ачигчийн тусламжтайгаар угаан баяжуулах төхөөрөмжийн хүлээн авах бункерт тэжээнэ. Алт агуулсан элсийг цагт 60 m^3 хүчин чадал бүхий скруббер, шлюзийн хослол бүхий багц тоног төхөөрөмжөөр угаан баяжуулна.

“Шийрийн хөндий” ордын бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Хүснэгт №7. “Шийрийн хөндий” ордын элс олборлолт /2024 он/

№	Ашиглалтын жил	Элс	Дундаж агуулга мг/м^3	Металл, кг	
				Шлих	Х.цэвэр
1	2024 он	95.53	201	22.44	19.21
	Нийт	95.53	201	22.44	19.21

Хүснэгт №8. Элс угаалт бүтээгдэхүүн гаргалт /2024 он/

№	Ашиглалтын жил	Элс	Дундаж агуулга мг/м^3	Металл авалт %	
				Шлих	Х.цэвэр
1	2024 он	95.53	172	19.31	16.47
	Нийт	95.53	172	19.31	16.47

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж

Хүснэгт №9. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн сонголт

Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Зориулалт	Тоо ширхэг
Хүлээн авах бункер	6 m^3	Анхдагч элс хүлээн авах	1
Скруббер, $\text{m}^3/\text{цаг}$	60	Алт агуулсан элсийг угаан ангилах	1
Баяжуулах ширээ, $\text{m}^3/\text{ц}$	2.0	Шлюзийн баяжмалыг гүйцээн баяжуулах	1
Эргэлтийн усны насос	12	Тунаах нуурнаас эргэлтийн ус шахах	1
Цэвэр усны насос	18200*500	Угаах тоног төхөөрөмжийг технологийн усаар хангах	1
Гүйцээн баяжуулах багц, хэрэгслүүд	-	Алт агуулсан элсний баяжмалыг гүйцээн баяжуулж шлихийн алт гаргаж авах	1

1.5. Дэд бүтэц

Уурхай ба тосгоны цахилгаан хангамж:

Уурхайн нь дизель хөдөлгүүрээр цахилгаан хангамжаа шийдэх болно.



Уурхайн усан хангамж:

1) Усан хангамжийн эх үүсвэр

Төсөл хэрэгжүүлэгч нь унд ахуйн усыг зөөврөөр, технологийн хэрэгцээний усыг карьерийн шүүрлийн усаар хангана.

Хүснэгт №10. Гүний худгийн мэдээлэл

№	Худгийн нэр	Үндарга, л/сек	Солбицол	Гүн, м	№
1	Худаг-1	2.0	46°12'02.10"	99°53'27.90"	1
2	Худаг-2	2.2	46°12'08.20"	99°55'28.60"	2
3	Худаг-3	2.5	46°12'14.10"	99°55'59.60"	3
4	Худаг-4	2.5	46°12'019.82"	99°56'01.80"	4
5	Худаг-5	3.8	46°12'13.80"	99°56'04.10"	5
Нийт ундарга		13.0		-	

2) Ус хэрэглээний тооцоо

Усны хэрэглээний тооцоог БОНХАЖ -ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаал “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм” -д тусгасан нормын дагуу гүйцэтгэсэн.

Алт олборлож байгаа үйлдвэрүүдийн туршлага, түүнчлэн “Шийрийн хөндий” алтны шороон ордын элс баяжуулах технологийн тооцоог баримталж шаардагдах усны 30%-ийг цэвэр усаар сэлбэх ба 70%-ийг технологийн эргэлтийн усаар хангах юм. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м.куб элс угаахад 4.0 м³ ус хэрэглэхээр тооцоолов.

Баяжуулах төхөөрөмжийн хаягдлыг эргэлтийн усан санд урсган хуримтлуулж, тунасан усыг эргүүлж, технологид ашиглана. Тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт болон шүүрлээс шалтгаалан алдагдал гардаг. Усан санд хуримтлуулсан усны шүүрэлтийг хязгаарлах зорилгоор усан санг зориулалтын нийлэг материалыар доторлоох төлөвлөж байна. Иймд уг алдагдлыг гадаад эх үүсвэрээс цэвэр усаар нөхөж, нуурын түвшинг тогтмол барьж байх шаардлагатай.

Хүснэгт №11. Жилд шаардлагатай технологийн усны нийт хэрэглээ

№	Элсний хэмжээ м ³	1 м ³ элс угаах усны хэмжээ м ³	Нийт усны хэрэглээ м ³	Эргэлтийн ус /70%/ м ³	Цэвэр ус /30%/ м ³
1	95,530	4	382,120	267,484	114,636

Хүснэгт №12. Хоногт шаардаагатай технологийн усны хэрэглээ

№	Элсний хэмжээ м ³	Эргэлтийн ус 70%	Цэвэр ус 30%	Жилд ажиллах хоног	Эргэлтийн ус м ³ /хон	Цэвэр ус м ³ /хон
1	95,530	267,484	114,636	128	2,089.7	895.6

Усан сан. “Шийрийн хөндий” алтны шороон ордын байрлаж буй бүс нутаг нь гадаргын ус байхгүй бөгөөд гүний худгаар технологийн усны хэрэгцээг хангана. Иймд усан сангийн байгууламжийг аль болох усны алдагдал бага байлгах зорилгоор зориулалтын нийлэг материалыар доторлоох төлөвлөсөн. Уурхайн усан сангийн бүтэц нь бидний төлөвлөж буйгаар 2 ширхэг тунаах нуур болон 1 ширхэг цэвэр усны нууртай байна.



Хүснэгт №13. Технологийн усан сангийн багтаамж

№	Нуурын эзэлхүүн м³		
	Тунаах нуур -1	Тунаах нуур -2	Цэвэр усны нуур
1	5,200	4,500	2,400
Нийт	12,100		



2. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

“Тогоотын ам” болон “Шийрийн хөндий” нэртэй орд нь Баянхонгорын алтны бүсийн Бөмбөгөрийн хүдрийн дүүргийн Бумбат булагийн хүдрийн зангилаанд орших ба ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт харьяалагдах ба Улаанбаатар хотоос баруун зүгт 760 км -т, Баянхонгор аймгийн төвөөс 98 км, Бөмбөгөр сумын төвөөс зүүн урагш 22 км зайд байр зүйн зургийн L-47-68 нэрлэбэрт байрлана. Улаанбаатар хот, Баянхонгор аймаг болон баруун бүсийг холбосон сайжруулсан авто зам тус ордын талбайгаас урагш 12 км -т өнгөрдөг байна.

“Тогоотын ам” болон “Шийрийн хөндий” нэртэй MV-017405 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь нийт 1724.73 га талбайг хамран байрлаж байна.

Хүснэгт №14. Төсөл хэрэгжих талбайн ашиглалтын төлөв байдал /2024 оны байдлаар/

№	Үзүүлэлт	Төлөв байдал	Талбай, га
1	Элэгдэл эвдрэлд өртөөгүй газар	Бага зэргийн сөөгөрхөг, дунд зэргийн чулуутай	1106.6
2		Бага зэргийн чулуурхаг	598.7
3	Ухсан нух	Хөрс, ургамалгүй	1.06
4	Овоолго	Хөрс, ургамалгүй	6.24
5	Кемп Оффис	Талхлагдсан	0.24
6	Авто засвар	Талхлагдсан	0.30
7	Зогсоол	Талхлагдсан	0.03
8	Хогийн цэг	Физик бохирдолтой	0.01
9	Өөрчлөлт орсон талбай	Талхлагдсан, ухагдсан	5.40
10	Карьер	Хөрс, ургамалгүй	6.15
	Дүн		1724.73

Төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна.

Төслөөс газрын гадарга, хэвлэлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ашиглалтын 5 жилийн хугацаанд нийтдээ “Тогоотын ам”-ны ордын хувьд ил уурхайн олборлолтонд 13.62 га, гадаад овоолгод дарагдах 0.35 га. угаах төхөөрөмж болон эфель гаалийн түр овоолго, усан сан түүний зам зэрэгт эвдрэлд өртөх талбай 1.47 бөгөөд нийт 15.45 га талбай, “Шийрийн хөндий”-н ордын хувьд ил уурхайн олборлолтонд өмнөх онуудад өртсөн 9.9 га, шинээр эвдрэлд 14.4 га, гадаад овоолгод өмнөх онуудад дарагдсан 1.2 га, угаах төхөөрөмж болон эфель гаалийн түр овоолго, усан сан түүний зам талбай, барилга байгууламж зэрэгт эвдрэлд өртөх талбай 1.7, технологийн тээврийн зам талбайд 1.9 га байх бөгөөд нийт 29.1 га талбай үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хамааран онцгой болон бага зэргийн эвдрэлд өртөнө.

2024 оны хувьд уурхайн олборлолтонд өртөх 1.27 га, гадаад овоолгод дарагдсан 0.42 га, барилга байгууламжууд баригдсан 0.8 га, угаах төхөөрөмж болон эфель галийн түр овоолго, усан сангийн зориулалтаар эвдрэлд өртөгдсөн талбай 2.24 бөгөөд нийт 4.73 га талбай үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хамааран онцгой болон бага зэргийн эвдрэлд өртөнө. Эдгээр эвдрэлд орсон талбайн үржил шимт хөрсийг тусгайлан 0.15-0.25 м хүртэлх зузаантайгаар хуулж шимт хөрсний овоолгод хадгалахаар тооцсон.



Хүснэгт №15. Уурхайн үйл ажиллагаагаар эвдэгдсэн газрын хэмжээ

д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Уурхайн малталтанд өртөх, га	Гадаад овоолгод дарагдсан	Угаах төхөөрөмж, барилга байгууламжид
1	MV-017405	1.27	0.42	3.04

Төслийн чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ил уурхайн хөрс хуулалт, тээвэрлэлт, овоолгоос үүсэх тоосжилт, дуу чимээ зэрэг нөлөөллөөс агаарын бохирдол үүснэ.

Төслийн гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн талбай нь Байдраг голын ай савд багтах ба төслийн талбайд гол горхи зэрэг гадаргын уст цэг байхгүй байна.

Төслийн талбай нь гидрогеологийн хувьд энгийн нөхцөлтэй хайгуул, алтны олборлолт хийхэд усан хангамжийг шүүрлийн усаар шийдсэн ба Баянхонгорын хагарлын бүс нь гидрогеологийн нөхцөл муутай, усжилтаар сулхан бүс нутагт хамрагдана.

Үс ашиглалтаас үүсэх нөлөөлөл - технологи, уурхайн унд ахуй, тоосжилт дарах зориулалтаар үс ашиглалтаас газрын доорх усны нөөц болон уст үед бага хэмжээний өөрчлөлт оруулна.

Үсны бохирдол - Уурхайн дотоод хяналт сурлах, санаатай болон санамсар болгоомжгүй байдлаар хөрсөнд шатах тослох материал болон хатуу хаягдлууд алдагдах нь хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулах эх үүсвэр болж болзошгүй.

Төслийн хөрсон бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

Тус нутаг нь Монгол орны хөрсний мужлалаар гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн хөрсний бүсэд хамаарна. Энэ бүсийн тал хээр нутгаар цайвар хүрэн, бор хөрс, голын хөндийн хэсгээр аллювиийн нутын хөрс, элсэргэх цайвар хүрэн, бор хөрс голлон тархсан байдаг.

Харин төслийн талбайд делювийн гарал үүсэлтэй хурдас дээр бий болсон, хөнгөн шавранцар болон элсэнцэр цөлөрхөг хээрийн бор хөрс тархсан байна. Гэхдээ тус газрын ашиглалт явуулж байсан болон одоо ашиглаж байгаа газар нь техникийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөлд орсон ухагдаж эвдэрсэн, физик бохирдолтой газар юм.

Хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг MNS 5850:2019 стандарттай харьцуулахад дээж №1 дээжинд хром 30.0 мг/кг, хар тугалга 80.6 мг/кг, цайр 40.7 мг/кг, зэс 30.9 мг/кг, никель 43.3 мг/кг агууламжтай, харин кадмий илэрсэнгүй. Дээж №3-ийн лабораторийн дүнгээс үзэхэд хром 18.8 мг/кг, хар тугалга 77.8 мг/кг, цайр 45.9 мг/кг, зэс 35.1 мг/кг, никель 45.1 мг/кг агууламжтай, мөн кадмий байхгүй байна.

Хар тугалгын агууламж шинжилгээнд хамруулсан бусад хүнд металлуудаас илүү хэмжээтэй байгаа нь шавранцар хөрсний хүлцэх дээд агууламжаас 7.8 мг/кг-аас 10.6 мг/кг-аар их байна. Харин задлан шинжилгээнд хамруулсан бусад хүнд металлуудын хувьд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага юм.

ТЭЗҮ -ийн тодотголд дурдсанаар төсөл хэрэгжих 5 жилийн хугацаанд 55.9 мян.м³ шимт хөрс хуулж, нийт 44.55 га талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлд оруулахаар байна.

Хөрсөн бүрхэвч нь ил уурхайн хөрс хуулалт, олборлолтыг гүйцэтгэх, тээврийн зам,



ашиглах явцад эвдэрч доройтохын зэрэгцээ шатах тослох материал санамсаргүй асгаснаас хөрсийг бохирдуулах эрсдэлтэй.

Төслийс ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Судалгааны явцад З цэг дээр ургамалжилт, төлөв байдлын бичиглэл хийж, ургамалжилтын төрхөөр цөлөрхөг хээрийн ургамалжилтын дараах 2 үндсэн бүлгэмдэлтэй байгааг тогтоов. Үүнд:

- Монгол өвс-таана-бударганат
- Таана-монгол өвст

Ил уурхайн олборлолт, тээвэрлэлт явагдах талбайн ургамлан нөмрөг дээрх үйл ажиллагаануудын нөлөөгөөр устаж доройтох нь зайлшгүй юм. Ургамлан нөмрөг нь олборлолт, тээвэрлэлтийн ажлын шатанд тоос шороо боссоны улмаас доройтно.

Төслийс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Тус нутаг нь хөхтөн амьтны газарзүйн мужлалаар (Банников, 1954)-аар Хойт доод муж, тайгын провинци, Хэнтий, Монгол Дагуурын хээрийн тойргуудад хамаарна. Уурхайн талбайн амьтны аймгийн судалгаагаар 1 зүйлийн шавж, 6 зүйлийн хоёр нутагтан мөлхөгчид, 21 зүйлийн шувуу, 6 зүйлийн хөхтөн, нийт 3 зүйлийн сээр нуруутан амьтдыг бүртгэн тэмдэглэв.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд хүн машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс, уурхайн олборлолтын үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн амьтдал шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Төслийс нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн талбайд оршин суугчид үгүй учир нутгийн иргэдийн газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөхгүй, нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд тодорхой хэмжээнд ажлын байраар хангагдана.
- Хамгийн ойр орших суурин газар нөлөөллийн бүсийн гадна байгаа тул сөрөг нөлөөлөлд өртөхгүй.

Уг төслийг хэрэгжүүлснээр нийт 20 хүний ажлын байр бий болсон бөгөөд нийт улс болон орон нутгийн төсөвт нийт 482.68 сая төгрөг хурилтуулахаар байна.

Уурхайн ажлын үед машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс ажилчдын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөтэй.

Төслийс түүх соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй бөгөөд илэрсэн тохиолдолд тэр даруйд нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагад мэдээллэх үүрэгтэй. Тус төслийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.



3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Тухайн жилийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт №16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Үрьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Уурхайн бүхий л үйл ажиллагаанд	-	-	2024.04-10 сар	<p>Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээхэвийн норм, түвшний хэмжээ</p>
	Овоолго болон тээвэрлэлтийн үед тоосжилт үүсгэж болзошгүй талбайнуудад усалгаа хийнэ.	Үйлдвэрийн байранд	-	Усны төлбөрт багтсан	5- 9 сар	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, засвар үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Үйл ажиллагааны турш	500.0	500.0	4- 10 сар, тогтмол	
Агаарын бохирдлын улмаас уурхай дахь ажлын нөхцөл, ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийнэ.	Үйл ажиллагааны турш	750.0	750.0	Сар бүр	
	Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (Хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээг нэмэлтээр хийх)	Уурхайн дотоот замд	-	200.0	2024.07 сард	
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах,	Ажиллах хугацаанд бүх хүнд	ҮАЗ-д	ҮАЗ-д	Сар бүр	
Нийт дун				1450.0		



Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
УСАН ОРЧИН						
Ус ашиглах	Гүний худагт хамгаалалтын бүс тогтоож ажиллах /5 гүний худагт/	Төслийн хүрээнд	500.0	500.0	2024 оны 07 сард	MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт -Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ Газар доорх усиг бохирдоос хамгаалах: MNS 3342:1982 БО, ЭМНХ-ын сайдын 1997оны 143А, 352/A тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	Ус ашиглалтын зөвшөөрөл авах, гэрээг байгуулж ажиллах, төлбөрийг цаг тухай бүр төлөх	Уурхай ажиллах нийт хугацаанд	Ашиглах усны хэмжээгээр	-	2024 оны 05 сард	
	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх арга хэмжээ авах, төловлөт боловсруулах	Үйл ажиллагааны турш	200.0	200.0	2024 он	
	Бороо цас үерийн ус цуглуулах сан байгуулах, тоосжилт дараах зорилгоор хэрэглэх, үерээс хамгаалах далан байгуулах	Талбайн сайруудад	-	YA3 -д тусгах	2024.06 сар	
Нийт дүн				700.0		
ХӨРС, УРГАМЛАН БҮРХЭВЧ						
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 2 м -ээс өндөргүй овоолон хадгалах	Үйл ажиллагааны турш	-	УАЗардалд	Шимт хөрс хуулах үед	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдхөд дээд хэмжээ MNS 5915:2008
	Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг хайрган хүчилттай болгох	Үйл ажиллагааны турш	-	-	2024 он	
	Хар тугалгын хэмжээ MNS 5850:2019 стандартаас давсан үзүүлэлттэй байгаа байршилд /46°10'16.0"N, 99°55'42.0"E/ давтан шинжилгээ хийх, бохирдолд өртсөн талбайн хэмжээг тодорхойлох, ургамлын төрөл зүйлийг нэмэгдүүлэх замаар хүнд металлыг саармагжуулах арга хэмжээг авах /царгас, харгана зэргийг тарих/	Биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг сайжруулах	-	1500.0	2024.08 сард	
Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Төслийн талбайд	-	-	Тогтмол	
	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар байрлуулах	Үйл ажиллагааны турш	-	250.0	2024 он	
Нийт дүн				1740.0		
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний зардал				3900.0		



3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт №17. 2024 оны нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал

Ажлын төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Нийт зардал мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт			2300.0	
Дотоод овоолгыг хэлбэршүүлэх	га	1.27	2300.0	
Биологийн нөхөн сэргээлт			1700.0	
Шимт хөрс ухаж ачих				MNS 6141:2010,
Шимт хөрс тээвэрлэх	га	1.27	1700.0	MNS 6138:2010,
Шимт хөрсийг тарааж тэгшлэх				6258-1:2011
Сүрлэн хучилт	га			MNS 5918:2008
Нийт дүн			4000.0	MNS 5917:2008

3.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

3.4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

3.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт №18. Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх,
бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа
1	Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалах боломжтой ижил төстэй экосистем бүхий нутагт мод тарих, ургамлан нөмрөг, амьтдын тархалтын мониторинг судалгааг хийх, хамгаалах арга хэмжээг авах, Шаардлагатай тохиолдолд биотехникийн ажил зохион байгуулах	Баянхонгор аймаг Бөмбөгөр суманд Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ бүлэгт тусгасан ижил төстэй экосистем бүхий дүйцүүлэн хамгаалах боломжтой нутаг дэвсгэрт/	-	3200.0	2024 онд
	Амьтдын тоо толгой буурах, дайжих амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомсдохоос хамгаалах	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрдэнэмандал хайрхан А хэсэгт 1 га, М хэсгийн 1.63 га талбайд ногоон байгууламж байгуулах.	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрдэнэмандал хайрхан А хэсэгт 1 га, М хэсгийн 1.63 га талбайд	-		2024 онд
		Тухайн бүс нутагт байрлах хашиж, хамгаалах шаардлагатай 3 булгийн эхийг хашиж хамгаалах.	Сум орон нутгийн зааж өгсөн булаг	-		2024 онд
2		“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд хамрагдаж нэгдсэн зохион байгуулалтаар мод тарьж, ургуулах, арчилжхамгаалах ажлуудыг хийж гүйцэтгэх	Аймгийн БОГазар болон сумын БОХУБ-ын зааж өгсөн газарт хийнэ.	-	Нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасан төлбөр	2024 он
Нийт дүн					3200.0	



3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №19. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай.	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаах дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Дотоод журам	2024 он
	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	-	Жилд 1 удаа
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	300.0	Жил бүр уурхай эхлэх үед
	Шатахууны агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тодорхой ажилтанд хариуцуулах	-	2024 он
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусlamжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	250.0	2024 оны 05 сард
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусlamж үзүүлэх, анхан шатны тусlamжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	-	Жил бүрийн 1 улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	-	2024 он
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникиуд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	<ul style="list-style-type: none"> - Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах 	Үйл ажиллагааны зардал	Жил бүр, жилд 1 удаа
Нийт дүн		550.0	



3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №20. Хог, хаягдаын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлцуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Уурхайн талбайд	-	600.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	ЗҮТ	-	-	2024 он	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	ЗҮТ	Хэрэглээний хэмжээгээр		2024 он	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдаын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Уурхайн ажилчид	-	-	2024 он	
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	-	Үйл ажиллагааны зардалд		2024 он	
Шингэн хог хаягдаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Бие засах газар, бохирын худгийг М^8 5924 : 2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” стандартын дагуу барьж ашиглах.	Ажилчдын сууринд	-	-	2024 онд	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	-	ҮАЗардалд тусгах	2024 онд	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ МК8 5885:2016
Нийт дүн				600.0		



3.8. БОМТ -г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт №21. БОМТ -г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны төв	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11 -р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах Хамтарч ажиллах	-
БОАЖЯ -ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн БОМТ, тайлан	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12 -р сар	-	-

3.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчинээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөлүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтэнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтануудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Хүснэгт №22. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө

Үрьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	тохиролцох	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Уурхайн гадаад тээврийн замыг засч сайжруулах	-	Уурхайн зардлаас	Төслийн хугацаанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль орчны аудит хийлгэх	Уурхай	-	2024 онд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Уурхай	-	2024 он	-
Нийт дүн			-	



3.10. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр


Хүснэгт № 23. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Уурхайлалт явагдаж буй талбайд	Aгаар-1 46° 11' 32.05" 99° 52' 40.26"	7 сард	Шинжилгээний зардал: 60.0 х жилд 1 удаа х 2 цэг НИЙТ 120.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	Aгаар-2 46° 09' 51.24" 99° 55' 59.17"			
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх				
Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний ерөнхий шинжилгээ хийлгэх	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Xөрс-1 46° 09' 47.45" 99° 52' 30.20" Хөрс-2 46° 12' 36.87" 99° 53' 07.34" Хөрс-3 46° 10' 43.04" 99° 55' 39.56" Хөрс-4 46° 10' 16.00" 99° 55' 42.00"	7 сард	4 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х /20.0/ НИЙТ 160.0 /Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж - 20.0 төг,	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	Дээрх 4 цэгт	7 сард	4 цэгт х 1 дээж х жилд 1 удаа х 20.0 Нийт 80.0 хүнд металлын шинжилгээ 1 дээж-20.0 төг/“ НартШҮҮН” лабораторын дүнгээр авав.	



Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Худаг-1 46° 12' 02.10" 99° 53' 27.90" Худаг -2 46° 12' 08.20" 99° 55' 28.60" Худаг -3 46° 12' 14.10" 99° 55' 59.60"	7 сард	НИЙТ 30.0 x 3 худаг = 90.0	MNS 0900 : 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Ургамлын аймаг						
3.1	Ургамал устах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл, бүрхэц, биоамасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биоамасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Ургамлын бичиглэл-1 46° 11' 03.13" 99° 53' 16.36" Ургамлын бичиглэл-2 46° 10' 03.33" 99° 53' 58.59" Ургамлын бичиглэл-3 46° 11' 12.73" 99° 54' 30.57"	7 сард		ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН				450.0		

Тус төслийг хэрэгжүүлэх ашиглалтын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **12,700.0** мян.төгрөгийг төлөвлөж байна.



Зураг № 3. Орчны хяналт шинжилгээний цэгийн байришлын зураг